



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/144

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага
худалдаа явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Сумын 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 36 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2016 оны "Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 9.11, 10.1.1 дэх, 10.2 дахь заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орсон Батноров сумын Бэрх 7-р багт 2024 оны 11 сарын 30-ны өдөр зохион байгуулагдах дуудлага худалдаануудын хугацаа, анхны үнэ болон холбогдох мэдээллийг хавсралтаар баталсугай.

2.Дуудлага худалдааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах бэлтгэл ажил хангахыг сумын газрын даамал /Т.Очирбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЖАВХЛАНБАЯР

230423337

Батноров сумын засаг даргын
2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
А/171 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Зориулалт	Байршил	Талбай хэмжээ м2	Нэгж талбарын тоо	Анхны үнэ	Дэнчин 10%	Эзэмших хугацаа
1		Уурхайчин	28	1	22400	2240	15
2		Уурхайчин	28	1	22400	2240	15
3		Уурхайчин	28	1	22400	2240	15
4		Уурхайчин	28	1	22400	2240	15
5		Уурхайчин	28	1	22400	2240	15
6		Уурхайчин	28	1	22400	2240	15
7		Уурхайчин	28	1	22400	2240	15
8		Уурхайчин	28	1	22400	2240	15
9		Уурхайчин	28	1	22400	2240	15
10		Уурхайчин	28	1	22400	2240	15
11		Уурхайчин	28	1	22400	2240	15
12		Уурхайчин	28	1	22400	2240	15
13		Уурхайчин	28	1	22400	2240	15
14	Орон сууц	Тосгон	857	1	685600	68560	15
15	Амралт аялал жуулчлалын газар	Төмөртэй өндөр	250	1	200000	2000	15
16	Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	Төмөртэй өндөр	55000	1	352000 00	3520000	15